



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 8/48

Чингис хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хар чонот ХХК” нэхэмжлэл гаргасантай холбогдуулан Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.3, 20.1.4, 20.1.5, 20.1.6, 20.1.7, 20.2.1, 20.2.2, 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.6, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.2.1-д заасан бүрэн эрхийг олгож Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн /Ц.Бат-Эрдэнэ/-г аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр /хэрэг хянан шийдвэрлэх хугацаагаар/ томилсугай.

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хариуцагчийг бүрэн төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн /Ц.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн A/42 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР



231030256